

БАТЛАВ: БАЙГАЛЬ ОРЧИН, УУР  
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ  
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

/ Т.БАЛЖИННЯМ /

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ  
ХҮЛЭЭСЭН: “БАДМААРАГ ХАШ” ХХК-  
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/ Г.УРАНГОО /



**“БАДМААРАГ ХАШ” ХХК-ИЙН СҮХБААТАР  
АЙМГИЙН ЭРДЭНЭЦАГААН СУМЫН НУТАГТ  
ОРШИХ “САЙН ХӨӨВӨР” ХҮРЭН НҮҮРСНИЙ ОРДЫГ  
ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН  
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-016679

“БАДМААРАГ ХАШ” ХХК: 5215919

ХЯНАСАН:

БОУАӨЯ -НЫ БНБХГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Ц. ЖАРГАЛНЭМЭХ

БОЛОВСРУУЛСАН:

“БАДМААРАГ ХАШ” ХХК-НЫ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Н.ОТГОНБАЯР

Улаанбаатар хот  
2026 он

## Агуулга

|                                                                                                                                   |    |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....                                                                                                     | 3  |
| 1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн талаар мэдээлэл .....                                                                                   | 3  |
| 1.2 Төслийн талбайн засаг захиргааны харьяалал.....                                                                               | 4  |
| 1.3 Дэд бүтэц, зам харилцаа .....                                                                                                 | 5  |
| 1.4 Ажиллах хүчний тухай мэдээлэл .....                                                                                           | 6  |
| 1.5 Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал .....                                                                    | 6  |
| 2 УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ.....                                                                                     | 10 |
| 2.1 Төслийн хүчин чадал, 2026 оны уулын ажлын төлөвлөгөө .....                                                                    | 10 |
| 3 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН<br>ТӨЛӨВ БАЙДАЛ .....                                            | 18 |
| 3.1 Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал .....                                                                    | 18 |
| 3.2 Төсөл хэрэгжиж буй нийгэм, эдийн засгийн төлөв байдал .....                                                                   | 21 |
| 4 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....                                                                                    | 21 |
| 4.1 Төслийн болзошгүй гол сөрөг нөлөөлөл .....                                                                                    | 21 |
| 5 2026 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....                                                                            | 26 |
| 6 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....                                                                      | 28 |
| 7 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....                                                                                              | 33 |
| 8 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....                                                                             | 34 |
| 9 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ<br>34                                                           |    |
| 10 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....                                                                    | 35 |
| 11 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....                                                                                   | 35 |
| 12 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....                                                                                      | 36 |
| 13 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....                                                                                       | 37 |
| 14 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД.....                                                                       | 40 |
| 15 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУТЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.... | 41 |

## ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн талаар мэдээлэл

|                                                                       |                                                                    |
|-----------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------|
| <b>Төслийн нэр:</b>                                                   | “Сайн хөөвөр” хүрэн нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл |
| <b>Төсөл хэрэгжих байриил:</b>                                        | Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сум                                   |
| <b>Төсөл хэрэгжүүлэгч:</b>                                            | “Бадмаараг Хаш” ХХК                                                |
| <b>Улсын бүртгэлийн дугаар:</b>                                       | 9019039141                                                         |
| <b>Регистрийн дугаар:</b>                                             | 5215919                                                            |
| <b>Хаяг:</b>                                                          | Улаанбаатар, Баянгол дүүрэг, 4-р хороо, 2 хороолол 92 401 тоот     |
| <b>Утас:</b>                                                          | +976-99090618                                                      |
| <b>Факс:</b>                                                          | +976-77110087                                                      |
| <b>БОННУ тайлан боловсруулсан тусгай зөвшөөрөл бүхий байгууллага:</b> | “Эко мастер” ХХК                                                   |
| <b>Хариуцах эзэн:</b>                                                 | Н.Отгонбаяр, Утас:94547877                                         |

#### Төслийн зорилго:

“Бадмаараг хаш” ХХК нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Баянцогтын хүрэн нүүрсний ордын Сайн хөөвөр нэртэй хэсгийг МУ-ын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр ашиглах, улс, орон нутгийн төсвийн орлогод бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг баримтлан аюулгүй ажиллагааг хангах, орон нутгийн ард иргэдийн оролцоот ажлын байрыг бий болгох, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу хийж орон нутагт хүлээлгэн өгөх, нийгмийн хариуцлагыг биелүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино.

“Бадмаараг Хаш” ХХК нь MV-016679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 755.55 га талбайг эзэмшдэг. Сайн хөөврийн хүрэн нүүрсний ордод 2008-2012 онд нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнд бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 44,554.43 мян.тн хүрэн нүүрсний нөөцийг батлуулсан ба уг нөөцийн хэмжээнд олборлолт явуулж, борлуулах үйл ажиллагаа 13 дах жилээ явагдаж байна. “Сайн хөөвөр”-ийн хүрэн нүүрсний ордод 2008-2009 онуудад явуулсан хайгуулын ажлаар ордын нийт нөөцийг В+С зэрэглэлээр 7596.4 мян.тн-оор тогтоож ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн байна. Мөн 2011-2012 онуудад тус ордын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор уул нэвтрэлт, өрөмдлөгийн ажлыг явуулж ордын нөөцийг дахин тооцсон. “Сайн хөөвөр”-ийн хүрэн нүүрсний нийт нөөцийг В+С зэрэглэлээр 44.55 сая тн-оор үнэлсэн. Үүнээс В зэрэглэлээр 25.43 сая тн, С зэрэглэлээр 19.12 сая тонноор тус тус тооцсон

2012 оны 05 сараас эхлэн одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Манай ашиглалтын талбайд хөрс хуулалтын “Шинэ Дорно Хөлийн гол Майнинг” ХХК, “Тэргүүн нандин хөрс” ХХК туслан гүйцэтгэхээр үйл ажиллагаа явуулж ажилладаг.


## 1.2 Төслийн талбайн засаг захиргааны харьяалал


Сайн хөөврийн тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны хувьд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт харьяалагдах бөгөөд Эрдэнэцагаан сумын төвөөс урагш 50 км, Баруун-Уртаас зүүн урагш 265 км, Улаанбаатар хотоос зүүн тийш 720 км, Бичигтийн боомтоос баруун урагш 78 км-т оршино. Ордын төв цэгийн солбицол уртраг 115°21'24.07" өргөрөг 45°28'11.09" байна. 755.55 га талбайг эзэмшдэг.

Төслийн талбайн солбилцолын цэгүүдийг доорх хүснэгтэнд, байршлыг доорх зурагт тус тус үзүүлэв.

Хүснэгт №01 Төслийн талбайн солбилцолын цэгүүд

| № | Уртраг          | Өргөрөг        |
|---|-----------------|----------------|
| 1 | 115° 21' 33.78" | 45° 28' 51.31" |
| 2 | 115° 21' 33.78" | 45° 28' 31.66" |
| 3 | 115° 22' 50.78" | 45° 28' 31.66" |
| 4 | 115° 22' 50.77" | 45° 27' 1.67"  |
| 5 | 115° 20' 54.19" | 45° 27' 1.67"  |
| 6 | 115° 20' 54.19" | 45° 28' 51.31" |





Зураг №01 Төслийн талбайн байршил

### 1.3 Дэд бүтэц, зам харилцаа

Уг нүүрсний ордыг түшиглүүлэн байгуулагдах нүүрсний ил уурхай дэд бүтцийн хувьд сайн хөгжсөн бүс нутагт байрладаг. Энэ орд газрын нүүрсийг Хятад улсад Бичигтийн боомтоор экспортлох бүрэн боломжтой нутагт тогтсон орд газрууд юм. Уурхай нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой зорчих, ажилчид тээвэрлэх, сэлбэг материал хэрэгсэл хүргэх зэрэг шаардлагатай үед аль ойрын аймаг, сум, суурингуудаас буюу Улаанбаатар хотоос тээвэрлэнэ.

Харилцаа холбоонд уурхайд богино долгионы радио станцыг ашиглах ба уурхайн орчимд бүх төрлийн үүрэн телефоны сүлжээ бүрэн нэвтэрсэн тул харилцаа холбоогоор бүрэн хангагдана.

Улаанбаатар- Сүхбаатар аймаг хүртэл хатуу хучилттай замаар зорчино. Эрдэнэцагаан сумыг аймгийн төвтэй холбогдсон шороон замтай, төслийн талбай хүртэл авто тээвэр зорчино. Төслийн талбайгаас Бичигтийн боомт хүртэлх 70 км зам мөн шороон замтай.



Зураг №2. Уурхайн ажилчдын байр

Сайн хөөвөрийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн талбайн барилга байгууламж ерөнхийдөө баруун, баруун хойд хэсэгт объектууд баригдсан байна. Үүнд:

- Ажилчдын байр /кемп/
- Халаалтын зуух
- Шатахуун түгээх цэг
- Авто засварын байр
- Сэлбэг хэрэгслийн агуулах
- Хамгаалалтын хашаа, пост тус тус хамаарна.
- 

#### **1.4 Ажиллах хүчний тухай мэдээлэл**

2025 оны хувьд 150 хүний бүтэц бүрэлдэхүүнтэй ажиллахаар төлөвлөсөн. Үүнд туслан гүйцэтгэгч компанийн нийт ажилчдын тоо орсон болно. Үүнээс 2025 онд 96% буюу 145 ажилтан ажилласан. Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн залуучуудыг сургаж, дадлагажуулан ажилд авч ажиллуулах, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах бодлого баримталж ажиллаж байна.

#### **1.5 Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал**

**Уул зүй:** Төслийн объект байршиж нутгийн хувьд Монголын Дорнодын талдраг мужид хамаарах бөгөөд Дорнодын талтрах их муж дотроо дов толгодтой талж, төгөлтэй талын, Хянганы гүвээт мужид хуваагдана. Монголдоо хамгийн нам дор орших нутаг юм. Монголын Дорнод тал урд талаараа далайн түвшнээс 1000–1500 м хүртэл өргөгдсөн, хойшоо болох тусам намссаар Буйр нуурын орчим 583 м хүртэл доошилно. Далайн түвшнээс дээш хамгийн өндөр цэг нь Ар булгийн баруун уул /1318 м/, хамгийн нам цэг нь талбайн зүүн захын Уушигийн тал орчимд /860 м/ юм. Талбайд Бүдүүн уул /1334 м/, Баян уул /1019 м/, Уушигийн уул /910 м/ зэрэг уулсын зэрэгцээ тэдгээрийн хооронд болон завсраар Хошууны говь, Хүрэн булгийн хөндий, Хуцын гол, Монголын буян гол, Уушигийн тал зэрэг байдаг юм.

**Ус зүй:** Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь ус зүйн хувьд Номхон далайн ай савд багтах боловч гадаргуугийн усан сүлжээ хөгжөөгүй. 1000 км<sup>2</sup> талбайд 50 км–ээс бага гол усны урсацтай буюу гол мөрний сүлжээний нягтаршлын хувьд бараг байхгүй гэж хэлж болно.

Гадаргуугийн урсац бага хэдий боловч талбайн төв хэсэгт Тэрэгтийн булаг, Хошууны нэрийн булаг, Уушигийн булаг, Чулууны булаг зэрэг булгууд болон Уушигийн хоолой, Хошууны говь хоолойнуудыг дагасан хуурай марз, шал, тойрмууд байдаг.

#### **Ордын гидрогеологи**

Нүүрс агуулагч хурдас нь элсэн чулуу, алевролит, гравеллит, конгломерат зэрэг терриген гаралтай чулуулгаас бүрэлдэх ба нүүрсний гол давхрагууд нь элсэн чулууны үе дотор байна. Дээр дурдсан нүүрс агуулагч хурдас нь ордын нийт талбайд дөрөвдөгчийн элс, шавранцар, гравий, галькаас бүрдсэн сэвсгэр хурдсаар хучигджээ. Хучиж буй дөрөвдөгчийн хурдасны литологи бүрэлдэхүүнийг үзэхэд уг хурдас нь хур тунадасны ус нэвчин шингэхэд тохиромжтой болно. Нүүрсний хайгуулын ажлын үед гидрогеологийн судалгааг дайвар маягаар явуулж өрөмдлөгийн дараа усны түвшинг үе үе хэмжиж нэг сорилын шавхалт хийж, 3 цооногийн усыг жижиг оврын цахилгаан насосоор шавхаж үзлээ. Өрөмдлөгийн явцад усны түвшингийн хэмжилт хийснээр цооногуудад ус 11.0-15.0м-ээс илэрч 6-7м өгсөж тогтож байна. Өөрөөр хэлбэл нүүрс агуулсан хурдас газар доорхи ус нь бага даралттай байна. 1, 7, 10-р цооногуудыг жижиг цахилгаан насосоор шавхаж үзэхэд усны түвшин 5.0-8.0м буурч усны ундарга 2.6 л/сек-ээс их ундаргатай байсан. Шавхалтын явц: Статик түвшин газрын гадаргаас 9.2 м байна. Ус шавхалтын үр дүнг хүснэгтлэн үзүүлэв.

*Хүснэгт №02. Ус шавхалтын үр дүн*

| Хугацаа | Ундарга<br>(л/с) | Динамик<br>түвшин(м) | Бууралт<br>(м) | Хугацаа<br>(цаг) | Ундарга<br>(л/с) | Динамик<br>түвшин<br>(м) | Бууралт(м) |
|---------|------------------|----------------------|----------------|------------------|------------------|--------------------------|------------|
| 9-20    | 1.63             | 9.2                  | -              | 16-00            | 3.1              | 14.6                     | -          |
| 9-50    | 2.21             | 9.7                  | 0.5            | 17-00            | 3.3              | 14.8                     | 0.2        |
| 10-20   | 2.21             | 10.4                 | 0.7            | 18-00            | 3.6              | 14.6                     |            |
| 11-50   | 2.21             | 10.6                 | 0.2            | 19-00            | 3.2              | 14.7                     |            |
| 12-20   | 2.21             | 10.9                 | 0.3            | 20-00            | 3.4              | 14.8                     | -          |
| 12-50   | 2.5              | 11.8                 | 0.9            | 24-00            | 3.42             | 15.1                     | 0.3        |
| 13-20   | 2.86             | 12.3                 | 0.5            | 04-00            | 3.71             | 15.4                     | 0.3        |
| 13-30   | 2.5              | 11.2                 | -              | 08-00            | 3.65             | 15.6                     | 0.2        |
| 14-00   | 2.7              | 12.4                 | 0.1            | 12-00            | 3.70             | 15.5                     | -          |
| 15-00   | 3.0              | 14.6                 | 2.2            | 18-00            | 3.72             | 15.5                     | -          |

Сайн хөөврийн ордын талбайд 2012 оны 6-р сард “Зэт энд икс” ХХК-иар ундны ус болон уурхайн усан хангамжийг хангах зорилгоор нийт 2 ш худаг өрөмдүүлж усны дээжийг УСУГ-ын Усны төв лаборатори шинжилгээнд хамруулсан байна.

**Ургамал зүй:** Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах хайгуулын талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дорнод монголын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Дорнод Монголын хуурай хээрийн тойрогт Дорнод Монголын тэгш тал, ухаа гүвээрхэг газрыг хамаарах Мэнэнгийн тал, урд хэсгээрээ Зотолхаан, Шилийн Богд, Алтан-овоо, Гангын Цагаан овоо зэрэг бэсрэг уулс, мөн Молцог, Онгон хэмээх 2 хэсэг элсэн манхан багтана. Энэ тойрогт умард зүгээс Дагуурын, өмнөөс Монголын ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан нийлж байгаа шилжилтийн бүс юм. Нөгөө талаар дорноос Манжуурын элементүүд багагүй нөлөөтэй. Тойргийн хувьд нийт 971 зүйл гуурст ургамалтай ба зөвхөн уг тойрогт тохиолддог 41 зүйл ургамал ургана. Ургамалшлын бүс бүслүүр /А.А.Юнатовынхаар/ хээрийн бүсэд хамаардаг. Хайгуулын талбайн ихэнхийг тал эзлэх учраас хуурай тал хээрийн хүрэн, говийн бор хөрс зонхилох ба бэлчээрийн ургамлаар баян юм. Таана, хөмүүл, хялганат хазаар, шивээ зэрэг бэлчээрийн ач холбогдолтой бутлаг ургамал зонхилно.

Эрдэнэцагаан сумын нутгийн өмнөд, зүүн хэсэг нь Егүзэрийн хээрийн районд багтдаг (А.А.Юнатов, Б. Дашням). Хиагийн эзлэх хувь их байхаас гадна 2 зүйлийн Хялгана, Хазаар өвс ихээр ургадаг. Гол тархах бүлгийн ургамал нь Хялганат-хазаар өвс, Хялганаи-агь, Хазаар өвст-хялгана-алаг өвс, жижиг үетэн-хазаар өвс эвшлүүд юм. Нам хотос, нөрийн хөндийгөөр сийрэгдүү дэрс бүхий ургамал улалж-хиагт эвшил бас зонхилон ургадаг.

Эрдэнэцагаан сумын нутагт Агь, Биелэг, Улалж, Сонгионо, Ортууз, Гичгэнэ, Хунчир, Тарна, Хялгана, Хазаар Өвс, Луулийн төрлийн ургамлууд зонхилон ургадаг. Энд 3-4 зүйлийн Хялгана, Хазаар өвс, Агь, Ерхөг, Биелэг, Дааган сүүл, Хиаг, Хиаглай түнх, 4-5 зүйлийн Шарилж, Хонин нүд, Навтуул, Түмэн таана, Өрөмтүүл, Тайжийн жинс, Дагуур хатны цэцэг, Хүж өвс, Хунчир, Гонтиг, Үхэр тарна, Багдай, Ганга зэрэг ургамлууд зонхилдог байна.

Тус сумын бэлчээр нь газар зүйн байршил, гадаргуугын зохистой харьцаатай, байгаль болон хүн малын нөлөөлөлд ороогүй, өвс ургамал сайтай, ус, хужир, мараа элбэгтэй. Бүх төрлийн малд тохиромжтой тал хээрийн ба нам хотос, газрын нарийн өвстэй бэлчээр юм.



Зураг №3. Монгол орны ургамал-газарзүйн мужлал

**Амьтны аймаг:** ТЗ-ын талбайд өвсөн тэжээлт амьтдаас туулай, бор гөрөөс, цагаан зээр, сохор номин байх ба махчин амьтдаас үнэг, чоно, хярс, элбэнх зэрэг амьтад нэлээд тохиолдоно. Жигүүртнээс тас, бүргэд, шар шувуу, сар, элээ, хэрээ, бор шувуу, харцага зэрэг олон төрлийн шувууд амьдардаг.

**Уур амьсгал:** Тусгай зөвшөөрлийн талбай нь уур амьсгалын хувьд манай орны бүх нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд дорнод хэсгийн хүйтэн өвөлтэй хуурай эх газрын мужид хамаардаг.

Жилийн дундаж температурын хэлбэлзэл -23.7 хэмээс +21.8 хэм байдаг. Хамгийн хүйтэн нэгдүгээр сард -31 хэмээс -35 хэм хүртэл хүйтэрдэг ба зуны хамгийн дулаан долоо дугаар сард +20-оос +25 хэм хүртэл халуун болдог. Жилд унах дундаж хур тунадасны хэмжээ 200-300 мм ба эдгээрийн зонхилох хувь нь зуны улиралд унах ба өвөлдөө уулархаг хэсгээр нэлээд цас унадаг цасан бүрхүүлийн зузаан 3-5 см хамгийн их нь 15-20 см хүрэх ба аравдугаар сараас тавдугаар сар хүртэл цастай байна.

Жилийн аль ч улиралд баруун хойноосоо зүүн урагшаа салхилдаг. Салхины хурд дунджаар 3-4.5 м/сек байдаг боловч улирлаар тэр ч байтугай нэг хоногийн дотор ч өөрчлөгддөг ялангуяа хавар намрын улиралд салхины хурд эрс нэмэгдэж 15 м/сек хүрэх түүнээс ч илүү гарах тохиолдол байдаг.

**Хөрс:** Эрдэнэцагаан сумын нутаг нь Төв Азийн их муж Хангайн дэд муж Монгол Дорнодын тойрогт хамаарагддаг байна. Тус нутгийн хөрс нь делюви, элюви, аллювийн хурдас дээр үүсч тогтсон байх ба Хүрэн хөрс нь ихэвчлэн делювийн хөвсгөр хурдас дээр, уулийн хөрс нь элювийн хурдас дээр, голын хөндийн хөрс нь аллювийн жижиг бөөрөнхий хайрга чулуун дээр үүссэн байна.

Хүснэгт №03 Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын  
хөрсний гарал үүслийн ангилал

| № | Төрөл             |                                    | Эзлэх хувь % |
|---|-------------------|------------------------------------|--------------|
| 1 | Хар хүрэн хөрс    |                                    | 2            |
| 2 | Хүрэн хөрс        | Дунд зэргийн зузаан хүрэн хөрс     | 40           |
|   |                   | Нимгэн хүрэн хөрс                  | 28           |
|   |                   | Карбонатлаг ба мараалаг хүрэн хөрс | 12           |
| 3 | Дов толгодын хөрс |                                    | 6            |

|      |                    |     |
|------|--------------------|-----|
| 4    | Нугын хөрс         | 5   |
| 5    | Голын хөндийн хөрс | 7   |
| Нийт |                    | 100 |

Хар хүрэн хөрс нь Эрдэнэцагаан сумын нийт нутгийн 2% -ийг эзэлнэ. Дангаараа үргэлжилсэн бүс үүсгэж чадахгүй алаг цоог тархана. Энэ хөрсний ялмагт үеийн зузаан нь дунджаар 32-38 см-ийн хооронд хэлбэлзэнэ. Карбонатын бөөгнөрөл 32-37см-ийн гүнээс ажиглагдана. Хөрсний давхаргад гөлтгөнө огт байхгүй. Хар хүрэн хөрс нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Делювийн хурдас дээр үүсч тогтсон хар хүрэн хөрсний дээд давхарга нь бараан хүрэн өнгөтэй, бөөмөнцөр бүтэцтэй, ялмагт үе нь нилээн зузаан, хөрсний давхарга нь нягтарч дагтаршсан хайрга, чулуу харьцангуй бага, 45-50см-ийн гүнээс карбонатлаг бөөгнөрөл нь үгүй болно.

Хүрэн хөрс нь Эрдэнэцагаан сумын нийт нутгийн 80%-ийг эзэлнэ. Энэ хөрс нь ихэвчлэн долгиорхог тэгш тал газраар тархсан байна. Үүнээс:

1. Дунд зэргийн зузаан хүрэн хөрс нь нийт нутгийн 50% -ийг эзэлнэ. Энэ хөрсний ялмагт үеийн зузаан дунджаар 30 см байх ба 26-30см-ийн хооронд хэлбэлзэнэ. Карбонатын бөөгнөрөл мөн 36 см-ээс гүнд харагдана. Механик бүрэлдэхүүнээрээ хөнгөн шавранцар түүний дотор дунд зэргийн ширхэгтэй элс их байна. Ялмагт давхарга доошлох тусам ялмаг агууламж багасна. Энэ хөрс бэлчээрт ашиглахад их тохиромжтой хөрс юм. Иймэрхүү газраас хадлан тэжээл бэлтгэх боломжтой.
2. Нимгэн хүрэн хөрс нь долгиорхог, хүтгэр годгортой тал газрын нийт 35%-ийг эзэлнэ. Энэ хөрсний ялмагт үеийн зузаан дунджаар 18 см байх ба 16-19 см-ийн хооронд хэлбэлзэнэ. Уг хөрс нь хоорондоо механик бүрэлдэхүүн, чулуурхаг байдлаар ялгаатай юм. Хөрсний гадарга нь жижиг чулуутай, элсэнцэр хүрэн хөрстэй ялзмагийн үе зузаан, хөнгөн шавранцар. Хөнгөн механик бүрэлдэхүүнтэй сийрэг, ус барьж тогтоохдоо муу.
3. Карбонатлаг ба мараалаг хүрэн хөрс нь нийт нутгийн 15%-ийг эзлэн тархан. Энэ хөрс нь ихэвчлэн долгиорхог талын хотгор гадаргад тархан. Эдгээр хөрсний ялмагт үеийн зузаан нь 9-36 см байх ба 7-40 см-ийн хооронд хэлбэлзэнэ. Эдгээр нь хоорондоо ялмагт үеийн зузаан механик бүрэлдэхүүн, чулуурхаг ба чулуутай байдлаараа ялгаатай. Карбонатлаг, мараалаг хүрэн хөрс нь үржил шим дунд зэрэгтэй.

Дов толгодын хөрс нь Эрдэнэцагаан сумын нийт нутгийн 6%-ийг эзэлнэ. Дов толгодын орой, налуу, хажуугаар элюви-делювийн болон элювийн хурдас дээр үүсэж тогтсон. Дов толгодын хүрэн хөрсний ялмагт үеийн зузаан нь дунджаар 20 см байна. Энэ хөрсөнд карбонатын бөөгнөрөл 24 см-ийн гүнээс ажиглагдана. Дов толгодын хүрэн хөрс нь үе давхаргуудын хөгжил муу, хөрсний үндсэн чулуулаг өнгөн давхаргад ойрхон, өнгөн гадаргуудаа жижиг чулуурхаг, ялмагт үе нимгэн зэрэг физик шинж чанартай байдаг.

Нугын хөрс нь Эрдэнэцагаан сумын нийт нутгийн 5%-ийг эзэлнэ. Нугын хөрсний 2 төрлийн шинж (нугын хар хүрэн хөрс, нугын хүрэн хөрс) илэрнэ. Нугын хөрс үүсэх нөхцөл нь чийглэг, ургамлын хувьд сайн, делювийн хөвсгөр карбонатлаг хурдас дээр үүснэ. Дов толгод хооронд нам дор газар, нарийхан хөндийд тархсан байдаг. Тухайн сумын хөрсөнд хуучин нугын үлдэгдэл шинж нилээд илэрч байна. Нугын хүрэн хөрс гол төлөв дов толгод, уулсын хооронд нарийн хөндийд нам дор газар тархах ба делювийн хурдас дээр үүсэж тогтсон байна. Энэ хөрс нь механик бүрэлдэхүүн, чулуурхаг болон карбонатлаг байдлаараа хоорондоо ялгаатай. Ялмагт үеийн зузаан нь 47 см байх ба 18-50 см-ийн хооронд ажиглагдана. Нугын хүрэн хөрс нь давслаг, сийрэг, бөөмөнцөр зэрэг физик шинж чанарыг агуулдаг.

Голын хөндийн хөрс нь Эрдэнэцагаан сумын нийт нутгийн 7%-ийг эзэлнэ. Аллювийн гаралтай өөрөөр хэлбэл урсгал буюу голын усны нөлөөн дор үүссэн хөрсүүд багтана. Ийм хөрс үүсэх гол нөлөөг ус үзүүлнэ. Тухайн бүс нутгийн ус чийг ихтэй нам дор газар буюу голуудын сав газраар тархсан. Энэ хөрсний онцлог нь газрын гадарга нь нугархаг зүлэгжсэн байна. Аллювийн нугын хөрсний өнгөн

гадарга нь дов сондуул ихтэй, микро гадарга илүү хөгжсөн, ус чийг элбэгтэй, түүнд зонхилсон намгийн өвслөг, дэрслэг сөөг гололсон ургамлын дор явагдана. Ялзмагт үе нь харавтар саарал, хөх саарал өнгөтэй доошлох тусам элсэрхэг болж харилцан адилгүй өнгөтэй ба механик бүрэлдэхүүн нь үелэн тогтсон байдгаараа бусад хөрснөөс онцлогтой юм.

## 2 УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

### 2.1 Төслийн хүчин чадал, 2026 оны уулын ажлын төлөвлөгөө

Уг төслийн нүүрс олборлолтын жилийн хүчин чадал дунджаар 1 сая тонн нүүрс бөгөөд нийтдээ 25-28 жилийн хугацаанд төслийн үйл ажиллагаа үргэлжилнэ гэж урьдчилсан байдлаар тооцсон байдаг. 2012 оны 06 сараас эхлэн төлөвлөгөөний дагуу одоог хүртэл явагдаж байна.

2026 оны Уулын ажил: Ашиглалтын 2026 онд нөөцийн 1, 2 давхаргаас олборлолт өртөнө (1-р давхарга: 1В, 2В, 6В, 7В, 8В, 4С, 8С, 11С 2-р давхарга: 2В, 3В, 9В, 10В, 11В, 2С, 6С) гэсэн геологийн блокуудээс нийт 2000.0 мян.тн нүүрс олборлож, 8788.7 мян.м³ хөрс хуулж,  $8788.7 \text{ мян.м}^3 \times 1.3 = 11424.5 \text{ мян.м}^3$  болж сийрэгжсэнээр хөрсний овоолгод нэмж хураана. Хөрс хуулалтын дундаж коэффициент 4.3 м³/тн байна. Төлөвлөлтийн 3-дах жилд уурхайн урт дунджаар 1318 м, өргөн 714 м, гүн нь 35 м байна.

2026 онд Хөрс хуулалт ил аргаар 8,788.7 мян.м³, 2000,0 тонн хүрэн нүүрс олборлохоор төлөвлөсөн.

**Ажиллах горим:** Уурхайн үйл ажиллагаа нь жилийн 4 улирлын турш тасралтгүй явагдах ба төсөл захиалагчийн саналын дагуу хоногт 10 цагийн 2 ээлжээр ажиллахаар тооцсон. Уурхайн бүтэн жилийн турш зайлшгүй амрах баяр ёслол, цаг агаарын саатал, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, зөөвөр нүүдэл зэрэгт дунджаар 65 хоног зарцуулна гэж үзвэл жилдээ 300 хоног буюу 6481 цаг ажиллах бүтэн жилийн хувьд (энэ жил). Уурхайн ажил эхлэх хугацаа 2026/01/01 гэж тооцож байна. 2026 онд ажиллах хоног 330 хоног бөгөөд хоногт 2 ээлжээр, ээлжинд 10 цаг ажиллана. Үндсэн компанид 30-35 хүн, туслан гүйцэтгэгч анги 115-125 хүн дунджаар ажиллахаар байна. Туслан гүйцэтгэгчээр “Тэргүүн нандин хөрс” ХХК, “Шинэ дорно хөлийн гол майнинг” ХХК ажиллана.

### Уурхайн ашиглалтын технологи:

#### Ухаж ачих хэсэг


2026 оны үйл ажиллагаандаа ашиглах техникийн жагсаалт. Доорх хүснэгтээс.

Хүснэгт №04. 2026 онд ажиллах техникийн жагсаалт

| №  | Техникийн марк                                                                                             | Зориулалт                | Тоо хэмжээ |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|------------|
| 1  | SANDVIK фирмийн D50KS маркийн                                                                              | өрмийн машин             |            |
| 2  | Hyundai-500 LC-7 маркийн эксковатор, Hyundai-450 LC маркийн экскаватор, Doosan DX520 LC маркийн экскаватор | Хөрс хуулалт             | 8          |
| 3  | Автосамосвал Terex TR45, Shacman F3000 маркийн автосамосвал                                                | Хөрс тээвэр              | 20         |
| 4  | Автогрейдер XGMA-M14                                                                                       | Зам талбайн тэгшлэлт     | 2          |
| 5  | Luigong 888 маркийн                                                                                        | утгуурт ачигч            | 5          |
| 6  | Дугуйт ачигч                                                                                               | Зам талбай, хөрс овоолго | 2          |
| 7  | CAT D8 маркийн бульдозер                                                                                   | хөрс овоолго             | 2          |
| 8  | Усны машин                                                                                                 | Зам усалгаа              | 1          |
| 9  | Үйлчилгээний машинууд                                                                                      | Ажилчидын хэрэгцээнд     | 6          |
| 10 | Shangdong дизель станц                                                                                     | Түлшний машин            | 2          |

#### Овоолго

“Сайн хөөвөр”-ийн ордыг 2012 оноос эхлэн ашиглаж эхэлсэн бөгөөд уулын ажлаар нийт 8974.0 мян.м3 хөрс хуулж уурхайн нээлтийг гүйцэтгэсэн одоогийн байдлаар 0.5 сая.тн нүүрс авахад бэлэн нээгдсэн байна. Иймд ордын ашиглах дарааллыг уурхайн жилийн хүчин чадал, хөрс хуулалт, нүүрсний давхаргын тогтоц, тээвэрлэлтийн зай, ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүдээс үндэслэн дараах байдлаар тогтоосон. Бадмаараг хаш ХХК нь “Сайн хөөвөр” нүүрсний ордод нийт 3 хэсгээс уурхайлан олборлож байна. Овоолгын ажилд ашиглаж байгаа SHANTUI үйлдвэрийн SD-32 маркийн бульдозер, 1ш Luigong-856 маркийн ачигчийг овоолгын ажилд ашиглаж байна. 2026 онд 5 га-д шимт хөрсний овоолго хийхээр төлөвлөсөн.



Зураг №04 Шимт хөрсний овоолго



*Зураг №05 Нүүрс буулгах талбай*

**Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц:**

Сайн хөөврийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн талбайн барилга байгууламж хойд хэсэгт объектууд байна. Үүнд:

- ✓ Уурхайн тосгон /кемп/
- ✓ Түлшний агуулах /түр/
- ✓ Туслан гүйцэтгэгч ангиудын кемп
- ✓ Засварын газар
- ✓ Шалган нэвтрүүлэх байр /харуул/
- ✓ Диспечерийн байр гэх мэт хамаарна



*Зураг №06 Уурхайн тосгон /кемп/*



*Зураг №07 Харуулын байр / Шалган нэвтрүүлэх байр/*

Түлшний агуулах

Дизель түлшний агуулах 40 тонны ёонкс байна. / түр агуулах / Мөн түлш тээвэрлэх цэнэглэх 6 дизель станц байна.



*Зураг №08 Түлшний агуулах*

Засварын байр

Сендвичин засварын байрыг ашиглалтанд оруулсан. Уулын олборлох, тээвэрлэх тоног төхөөрөмж болон бусад өөрөө явагч хүнд даацын машин механизмуудын засвар үйлчилгээ хийгдэж байна.



*Зураг №09 Засварын байр*

Уурхайн дотоод зам

Ашиглалтын талбайд нийт 3,8 км замыг ашиглаж байна. Үүнээс 2,8 км замд хайрга чулуу дэвссэн байна. Үлдэгдэл 1,0 км нь карьер болон хөрсний овоолго руу явах чиглэлд байна. Монголын улсын замын хөдөлгөөний дүрмийн дагуу уурхайд ашиглагдаж буй замын тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.



Зураг №10 Уурхайн дотоод зам

#### Харилцаа холбоо

Холбоо харилцааны хувьд уурхай нь Мобиком, Жи-Мобайлын сүлжээтэй. Уурхайд богино долгионы сувагтай радио станцыг ашиглаж байна.

#### Цахилгаан хангамж

Төсөл хэрэгжиж буй газраас ойр эрчим хүчний шугам байхгүй тул тэр орчмын уурхайнууд цахилгааны хэрэгцээгээ дизель станц ашиглан өөрсдөө хангадаг. Тус уурхайн хувьд 90кВт/6ВТ 5.9-G2-ийн хүчин чадал бүхий GSW-220Б маркийн дизель цахилгаан үүсгүүрээр цахилгааны хэрэгцээгээ хангадаг.



Зураг №11 Цахилгаан үүсгүүр

#### Уурхайн усан хангамж

Усны эх үүсвэр нь унд ахуй, технологийн хэрэгцээнд уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалаад уурхайн хүн амын 2 худгийг сэлгэн ээлжлэн ашигладаг. 1 худаг нь туслан гүйцэтгэх анги ашигладаг. Ундарга 3л/сек, Усны нөөц 259.2 м3 хүрэлцээтэй. Ажилтнуудын унд-ахуйн хэрэгцээний усыг ундны

усны стандартыг хангасан худгаас хангадаг бөгөөд тоолуур суурилуулан усны хэрэглээндээ хяналт тавин ажиллаж байна.

Уурхайн шүүрлийн усыг зумфэнд хуримтлуулах усан сангийн хэмжээ 5000 м<sup>3</sup> багтаамжтай. Зумфийг засаж сайжруулж стандартын дагуу шавхан ажиллаж байна. Уурхайн шүүрлийн усыг 116м урттай 250мм голчтой уян хоолойгоор дамжуулан ЦНС-300/120 маркийн насос ашиглан шавхан усан санд нийлүүлдэг. Шүүрлийн усыг шавхан зайлуулахдаа цахилгаан соронзон том диаметртай тоолуур суурилуулан сар бүр сум орон нутгаас бичилт хийж акт үйлддэг.

Ундын усны эх үүсвэрийг хамгаалалтын бүс тогтоон, хашаажуулан тэмдэгжүүлэн ажилласан.

### **Технологийн болон ахуйн хэрэглээ**

Ахуйн хэрэглээний усан хангамж. Уурхайд дунджаар 150 хүн ажиллах бөгөөд ахуйн хэрэглээний нормын дагуу 1 хүний хэрэглээнд 100л, ажлын байранд 1 ажилчны техникийн хэрэгцээнд 50л, нийт 150л ус зарцуулагдана. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-301 дүгээр тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн хэрэгцээнд:

$150\text{хүн} \times 150\text{л/хон} \times 300 = 6750.0\text{м}^3$  Ундны усыг Уурхайн хуучин тосгонд гаргасан 2ш худгаас хангана.

Технологийн хэрэглээний усан хангамж. Ил уурхайд технологийн ус нь хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын үед дотоод тээврийн замыг чийглэх /тоосжилт/ дарах зорилгоор ашиглах усыг уурхайн шүүрлийн уснаас авч ашиглана. Иймд ил уурхайн тоосжилтыг багасгах зорилгоор уурхайд 20.0 тн-н зориулалтын HOWO маркийн тоноглогсон усалгааны машинаар шүүрлийн технологийн замыг усална.  $60\text{м}^3/\text{хон} \times 180 = 10800\text{м}^3$

2026 оны уулын ажлын төлөвлөгөөнд 10,750м.куб усыг хүн амын унд, ахуйн зориулалтаар ашиглахаар төлөвлөсөн байна.

### **Уурхайн ус шүүрүүлэлт.**

Газар доорх усны түвшин гидрогеологийн судалгааны ажлаар 15.2-18.2 метрт, дунджаар 16 метрт тогтоогдсон. Гэж гидрогеологийн тайланд тусгасан байдаг. Энэ түвшнээс эхлэн газар доорх усны шүүрэлт ил уурхайн малталтууд, шүүрч байгаа усыг дренажаар (суваг) дамжуулан уурхайн ёроолын хэсэгт байгуулсан зумпфэд (ус хураагуур) хуримтлуулан насосоор шавхан зайлуулдаг. Шавхан зайлуулах усны хэмжээ  $/298.6\text{м}^3/\text{хон}$  ТЭЗҮ-ээр авсан.  $/298.6\text{м}^3/\text{хон} \times 200 = 59064.5\text{м}^3$

2026 оны уулын ажлын төлөвлөгөөнд 70,064.5 м.куб усыг шүүрлийн усыг шавхан зайлуулж үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахаар төлөвлөсөн байна.

### **Усны зардал**

Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны төлбөрийн хэмжээ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 заалтын дагуу унд-ахуйд жилд ашиглах  $6750.0\text{м}^3$  усыг төлбөрөөс чөлөөлнө. Шавхан зайлуулах  $56734.0\text{м}^3$  шүүрлийн усны төлбөрийн хэмжээг Монгол улсын засгийн газрын 2011 оны 10-р сарын 26-ны өдрийн 302 тоот тогтоолоор Мэнэнгийн талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолд заасан хувь хэмжээг ашиглан төлбөрийг тооцсон.

Шавхан зайлуулах газрын доорх усны төлбөр:  $1\text{м}^3$  газрын доорх усны үнэ:  $3700\text{төг}/\text{м}^3 \times 0.15 \times 1.4 = 777\text{төг}$

$3700\text{төг}/\text{м}^3$ -Мэнэнгийн талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ, 15%-газрын доорх усыг шавхан зайлуулсныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ 1.4-газрын

доорх ус шавхан зайлуулсныг тооцох итгэлцүүр,  $59064.5 \times 777 = 45.89$  сая.төг 2025 онд ТЭЗҮ-ийн тодотголоор 45.89 сая.төгрөг усны зардал гаргана гэж тооцсон байна.



Зураг №12. Ундны худаг



Зураг №13. Шүүрлийн ус



Зураг №14. Тоолууржуулалт

### 3 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

#### 3.1 Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал

**Уур амьсгалын үндсэн нөхцөл:** Төслийн объект байрших нутаг газарзүйн хувьд Монголын Дорнодын талархаг мужид хамаарах бөгөөд Дорнодын талархаг их муж дотроо дов толгодот талын, тэгш талын, Хянганы гэсэн гурван мужид хуваагдах бөгөөд Монголдоо хамгийн нам дор орших нутаг юм. Монголын Дорнод тал урдуураа далайн түвшнээс 1000-1500м хүртэл өргөгдсөн, хойшоо болох тутам намассаар Буйр нуурын орчим 583 м хүртэл доошлоно.

Агаар мандлын тогтворшлын явцтай уялдан Монгол оронд хүчтэй салхи сайтар илэрсэн хоногийн явцтай. Өдрийн цагт өнгөн хөрс, тэр хавийн агаарын доод нимгэн үе давхрага хүчтэй халж, эрчлэл солилцоо идэвхжиж, шөнө салхины хурд 15 м/с хүрэхгүй байсан даралтын шатлууртай нөхцөлд өдрийн цагт 15 м/с ба үүнээс хүчтэй салхи гарна. Өдрийн 12-15 цагийн хооронд нийт хүчтэй салхины 23.4% нь тохиолдож байхад шөнө 3-6 цагийн хооронд дөнгөж 5.8% нь оногдоно. Өглөөний 6 цагаас оройн 20 цагийн хооронд хоногийн бүх хүчтэй салхины 71.2%. 9-18 цагийн хооронд 58.4% нь ажиглагдана. Хүчтэй салхины жилд үргэлжлэх хугацааг авч үзвэл Эрдэнэцагаанд 104 цаг, Эрдэнэцагаанд 62 цаг болно. Төслийн бүс нутагт жилийн дундаж байдлаар баруун, баруун хойд чиглэлийн салхи зонхилно.

**Уул зүй:** Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр нь Дорнод Монголын тэгш талын өмнөд хэсгийн үргэлжлэл бөгөөд тал хээрийн бүсэд багтдаг. Нутгийн ихэнх хэсэг нь далайн түвшнээс дээш 1000-1200 метр өндөрт оршдог. Хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1778 метрт өргөгдсөн Шилийн Богд уул, хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 790 метр өргөгдсөн Байшинт юм.

Далайн түвшнөөс дээш хамгийн өндөр цэг нь Бүдүүн уул /1334.0/ хамгийн нам цэг нь талбайн зүүн захын Уушигийн тал орчимд /860.0м/ юм. Талбайд Ар булгийн баруун уул / 1318.0/, Баян уул/1019.0, Уушигийн уул / 910.0 / зэрэг уулсын зэрэгцээ тэдгээрийн хооронд болон завсараар Хошууны говь, Хүрэн булгийн хөндий, Хуцын гол, монголын буян гол, Уушигийн тал зэрэг байдаг юм.

**Ус зүй:** Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь ус зүйн хувьд Номхон далайн ай савд багтах боловч гадаргуугийн усан сүлжээ хөгжөөгүй. 1000 км<sup>2</sup> талбайд 50 км–ээс бага гол усны урсацтай буюу гол мөрний сүлжээний нягтаршлын хувьд бараг байхгүй гэж хэлж болно.

Гадаргуугийн урсац бага хэдий боловч талбайн төв хэсэгт Тэрэгтийн булаг, Хошууны нэрийн булаг, Уушигийн булаг, Чулууны булаг зэрэг булгууд болон Уушигийн хоолой, Хошууны говь хоолойнуудыг дагасан хуурай марз, шал, тойрмууд байдаг.

**Ургамал зүй:** Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах хайгуулын талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дорнод монголын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Дорнод Монголын хуурай хээрийн тойрогт Дорнод Монголын тэгш тал, ухаа гүвээрхэг газрыг хамаарах Мэнэнгийн тал, урд хэсгээрээ Зотолхаан, Шилийн Богд, Алтан-овоо, Гангын Цагаан овоо зэрэг бэсрэг уулс, мөн Молцог, Онгон хэмээх 2 хэсэг элсэн манхан багтана. Энэ тойрогт умард зүгээс Дагуурын, өмнөөс Монголын ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан нийлж байгаа шилжилтийн бүс юм. Нөгөө талаар дорноос Манжуурын элементүүд багагүй нөлөөтэй. Тойргийн хувьд нийт 971 зүйл гуурст ургамалтай ба зөвхөн уг тойрогт тохиолддог 41 зүйл ургамал ургана.

А.А.Юнатов, 1976 судалгаагаар ургамалын газар зүйн мужлалаар Евроазийн хээрийн мужийн, Дагуур Монголын хээрийн провинцийн, Дорнод Монголын хээрийн тойргийн Дарьгангын галт уулсын, Бяруутын, Егүзэрийн хээрийн районы хэсэгт хамаарагдана гэж тогтоосон байдаг. Дорнод Монголын уужим тэнүүн тэгш тал, ухаа гүвээ, уужим тэгш газар нь Мэнэнгийн тал орно. Урд хэсгээрээ Зотолхаан, Шилийн Богд, Алтан-овоо, Гангын Цагаан овоо зэрэг бэсрэг уулс бүхий хүрмэн чулуугаар бүрхмэл юм. Бас тэнд Молцог, Онгон элс хэмээх 2 хэсэг элсэн манхан бий.

Дорнод Монголын хуурай хээрийн тойрогт Дорнод Монголын тэгш тал, ухаа гүвээрхэг газрыг хамаарах Мэнэнгийн тал, урд хэсгээрээ Зотолхаан, Шилийн Богд, Алтан-овоо, Гангын Цагаан овоо зэрэг бэсрэг уулс, мөн Молцог, Онгон хэмээх 2 хэсэг элсэн манхан багтана. Энэ тойрогт умард зүгээс Дагуурын, өмнөөс Монголын ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан нийлж байгаа шилжилтийн бүс юм.

Бяруутын район нь Эрдэнэцагаан сумын нутгийн төв ба хойт хэсгүүдээр нэлээд их хэмжээний талбайг эзлэх бөгөөд ихэнх бэлчээр нь энд хамаарна. Зүүн хойд чиглэлд сунаж тогтсон нам хотос,

хоолойнууд болон тэдгээрийн хооронд орших тэгш ба долгиорхог талууд өргөн уудам нутгийг хамаарна. Хотос, хоолой нь маш аажмаар тэгш тал руу шилжинэ. Энд алаг цоог, хужир мараат цагаан өнгийн шаварлаг толбууд болон жижиг тойрмууд элбэг тохиолдоно. Гол төлөв дэрс зарим газраар Бударгана, Таана зонхилон, Хиаг, Агь шарилж элбэг ургадаг. Эрдэнэцагаан сумын нутагт Хялганат-хазаар өвс, жижиг үетэн-хялгана-агьт (шарилжит), Хялгана-сөөгт, Хялгана-хиагт- алаг өвст, Хиаг-дэрст эвшлүүд тохиолдоно.

Сүүлийн үед зарим зүйл ургамалын ургац удаашран цэцэглэж чадахгүй байдалд орж байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлттэй нэн холбоотой юм. Эрдэнэцагаан сумын нутагт Агь, Биелэг, Улалж, Сонгионо, Ортууз, Гичгэнэ, Хунчир, Тарна, Хялгана, Хазаар Өвс, Луулийн төрлийн ургамлууд зонхилон ургадаг. Энд 3-4 зүйлийн Хялгана, Хазаар өвс, Агь, Ерхөг, Биелэг, Дааган сүүл, Хиаг, Хиаглай түнх, 4-5 зүйлийн Шарилж, Хонин нүд, Навтуул, Түмэн таана, Өрөмтүүл, Тайжийн жинс, Дагуур хатны цэцэг, Хүж өвс, Хунчир, Гонтиг, Үхэр тарна, Багдай, Ганга зэрэг ургамлууд зонхилдог байна.

Дорнод Монголын хээрийн тойргийн Өмнөд хэсэгт ургамлын ерөнхий бүрхэц 40-60%-иас хэтрэхгүй, алаг өвс нь хээрт ерөнхий бүрхэц 50% хүрэх нь цөөнгүй. Ургамлын ерөнхий өндөр 10-25см байдаг. Энд Хялгана-хазаар өвст хээрийн аспект голдуу цайвар ногоон нь хэвийн өнгөтэй байдаг байна. Намар агийн ургалт сэргэж цэцэглэх үед цайвар өнгө улам тодорч бууралдуу өнгөтэй болно. Хэрэв Хонин нүд элбэг бол цагаан өнгөтэй болдог. Тус сумын бэлчээр нь газар зүйн байршил, гадаргуугийн зохистой харьцаатай, байгаль болон хүн малын нөлөөлөлд ороогүй, өвс ургамал сайтай, ус, хужир, мараа элбэгтэй. Бүх төрлийн малд тохиромжтой тал хээрийн ба нам хотос, газрын нарийн өвстэй бэлчээр юм.

Төслийн талбай нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө хээрийн ургамалжилтай бөгөөд 2 хэвшинж, 2 хэвшил, 3 бүлгэмдэл болгон ангиллаа.

**Амьтны аймаг:** Тус суманд Буга, бор гөрөөс, цагаан зээр, тарвага, үнэг, чоно, мануул байхаас гадна цөөн тооны илбэнх, хар сүүлт, шилүүс байдаг. Жигүүртнээс Хахилаг, Хулан жороо, Тагтаа, Ногтруу, Бүргэд, Ёл, Тас, Элээ, Хэрээ, усны шувуудаас Хун, Ангир,Тогоруу, Галуу, Нугас зэрэг шувууд нүүдэллэн ирэхээс гадна 9-р сарын сүүлээр Ганга нууранд хунгийн чуулган болж зэргэлдээ талбайн Дуут нууранд 1000 орчим хун чуулдагтай адил байгалийн үзэсгэлэнт төрхийг илэрхийлдэг.Ордын талбайн орчимд цагаан зээр, чоно, тарвага, үнэг, хярс, дорно, туулай, зурам, зараа зэрэг амьтад амьдарч идээшилдэг. Тусгай хэрэгцээний хамгаалалттай Лхачинвандад уул, Хамар замт уул, Холбоо залаа уул орчимд цөөн тоонй буга, гөрөөс нутагшин амьдардаг.

**Уур амьсгал:** Эрдэнэцагаан нь Монгол орны уур амьсгалын мужлалаар сэрүүн зунтай, хахирдуу өвөлтэй мужид багтана. 2001 оноос хойш хийсэн судалгаагаар сумын төв орчмын нутаг дэвсгэрийн 25 орчим хувийг хамарсан ган 2-3 жилд нэг удаа, 50% түүнээс дээш нутагт тархсан ган 4-5 жилд нэг удаа тохиолдсон байна. Жилийн цэлмэг өдрийн тоо 95-100 хоног, хүйтрэлтгүй үеийн үргэлжлэх хугацаа 110 хоног байдаг. Жилийн дундаж температур 0.4 хэм, дулааны улирлынх 12.6 хэм, өвлийнх -11.8 хэм байдаг. Жилийн дундаж хур тунадас 20.3 мм байх ба жилд хамгийн ихдээ 189.3 мм хүрдэг. Нийт унах хур тунадасны 85 хувь нь дулааны улиралд, 15 хувь нь өвлийн улиралд тус тус унадаг. Салхины хурдны дундаж хэмжээ баруун хойноос 4.5-5.6 м/с байна. Шороон шуурга хаврын улиралд их тохиолддог.

**Хөрс:** Монгол орны хөрсний ангиллаар Хархүрэн хөрсний дэд хэв шинжид багтах ердийн ба карбонаттай, глейрхэг (нугархаг) төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна.Сайн хөөврийн орд байрших Эрдэнэцагаан сумын нутаг нь хүрэн хөрс давамгайлдаг бөгөөд Төв Азийн их муж Хангайн дэд муж Монгол Дорнодын тойрогт хамаарагддаг байна.

Тус нутгийн хөрс нь делюви, элюви, аллювийн хурдас дээр үүсч тогтсон байх ба Хүрэн хөрс нь ихэвчлэн делювийн хөвсгөр хурдас дээр, уулийн хөрс нь элювийн хурдас дээр, голын хөндийн хөрс нь аллювийн жижиг бөөрөнхий хайрга чулуун дээр үүссэн байна.

*Хүснэгт №04 Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын хөрсний гарал үүслийн ангилал*

| № | Төрөл          |                                | Эзлэх хувь % |
|---|----------------|--------------------------------|--------------|
| 1 | Хар хүрэн хөрс |                                | 2            |
| 2 | Хүрэн хөрс     | Дунд зэргийн зузаан хүрэн хөрс | 40           |

|      |                    |                                    |     |
|------|--------------------|------------------------------------|-----|
|      |                    | Нимгэн хүрэн хөрс                  | 28  |
|      |                    | Карбонатлаг ба мараалаг хүрэн хөрс | 12  |
| 3    | Дов толгодын хөрс  |                                    | 6   |
| 4    | Нугын хөрс         |                                    | 5   |
| 5    | Голын хөндийн хөрс |                                    | 7   |
| Нийт |                    |                                    | 100 |

Хар хүрэн хөрс нь Эрдэнэцагаан сумын нийт нутгийн 2% -ийг эзэлнэ. Дангаараа үргэлжилсэн бүс үүсгэж чадахгүй алаг цоог тархана. Энэ хөрсний ялзмагт үеийн зузаан нь дунджаар 32-38 см-ийн хооронд хэлбэлзэнэ. Карбонатын бөөгнөрөл 32-37см-ийн гүнээс ажиглагдана. Хөрсний давхаргад гөлтгөнө огт байхгүй. Хар хүрэн хөрс нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Делювийн хурдас дээр үүсч тогтсон хар хүрэн хөрсний дээд давхарга нь бараан хүрэн өнгөтэй, бөөмөнцөр бүтэцтэй, ялзмагт үе нь нилээн зузаан, хөрсний давхарга нь нягтарч дагтаршсан хайрга, чулуу харьцангуй бага, 45-50см-ийн гүнээс карбонатлаг бөөгнөрөл нь үгүй болно.

Хүрэн хөрс нь Эрдэнэцагаан сумын нийт нутгийн 80%-ийг эзэлнэ. Энэ хөрс нь ихэвчлэн долгиорхог тэгш тал газраар тархсан байна. Үүнээс:

4. Дунд зэргийн зузаан хүрэн хөрс нь нийт нутгийн 50% -ийг эзэлнэ. Энэ хөрсний ялзмагт үеийн зузаан дунджаар 30 см байх ба 26-30см-ийн хооронд хэлбэлзэнэ. Карбонатын бөөгнөрөл мөн 36 см-ээс гүнд харагдана. Механик бүрэлдэхүүнээрээ хөнгөн шавранцар түүний дотор дунд зэргийн ширхэгтэй элс их байна. Ялзмагт давхарга доошлох тусам ялзмаг агууламж багасна. Энэ хөрс бэлчээрт ашиглахад их тохиромжтой хөрс юм. Иймэрхүү газраас хадлан тэжээл бэлтгэх боломжтой.
5. Нимгэн хүрэн хөрс нь долгиорхог, хүтгэр годгортой тал газрын нийт 35%-ийг эзэлнэ. Энэ хөрсний ялзмагт үеийн зузаан дунджаар 18 см байх ба 16-19 см-ийн хооронд хэлбэлзэнэ. Уг хөрс нь хоорондоо механик бүрэлдэхүүн, чулуурхаг байдлаар ялгаатай юм. Хөрсний гадарга нь жижиг чулуутай, элсэнцэр хүрэн хөрстэй ялзмагийн үе зузаан, хөнгөн шавранцар. Хөнгөн механик бүрэлдэхүүнтэй сийрэг, ус барьж тогтоохдоо муу.
6. Карбонатлаг ба мараалаг хүрэн хөрс нь нийт нутгийн 15%-ийг эзлэн тархан. Энэ хөрс нь ихэвчлэн долгиорхог талын хотгор гадаргад тархан. Эдгээр хөрсний ялзмагт үеийн зузаан нь 9-36 см байх ба 7-40 см-ийн хооронд хэлбэлзэнэ. Эдгээр нь хоорондоо ялзмагт үеийн зузаан механик бүрэлдэхүүн, чулуурхаг ба чулуутай байдлаараа ялгаатай. Карбонатлаг, мараалаг хүрэн хөрс нь үржил шим дунд зэрэгтэй.

Дов толгодын хөрс нь Эрдэнэцагаан сумын нийт нутгийн 6%-ийг эзэлнэ. Дов толгодын орой, налуу, хажуугаар элюви-делювийн болон элювийн хурдас дээр үүсэж тогтсон. Дов толгодын хүрэн хөрсний ялзмагт үеийн зузаан нь дунджаар 20 см байна. Энэ хөрсөнд карбонатын бөөгнөрөл 24 см-ийн гүнээс ажиглагдана. Дов толгодын хүрэн хөрс нь үе давхаргуудын хөгжил муу, хөрсний үндсэн чулуулаг өнгөн давхаргад ойрхон, өнгөн гадаргуудаа жижиг чулуурхаг, ялзмагт үе нимгэн зэрэг физик шинж чанартай байдаг.

Нугын хөрс нь Эрдэнэцагаан сумын нийт нутгийн 5%-ийг эзэлнэ. Нугын хөрсний 2 төрлийн шинж (нугын хар хүрэн хөрс, нугын хүрэн хөрс) илэрнэ. Нугын хөрс үүсэх нөхцөл нь чийглэг, ургамлын хувьд сайн, делювийн хөвсгөр карбонатлаг хурдас дээр үүснэ. Дов толгод хооронд нам дор газар, нарийхан хөндийд тархсан байдаг. Тухайн сумын хөрсөнд хуучин нугын үлдэгдэл шинж нилээд илэрч байна. Нугын хүрэн хөрс гол төлөв дов толгод, уулсын хооронд нарийн хөндийд нам дор газар тархах ба делювийн хурдас дээр үүсэж тогтсон байна. Энэ хөрс нь механик бүрэлдэхүүн, чулуурхаг болон карбонатлаг байдлаараа хоорондоо ялгаатай. Ялзмагт үеийн зузаан нь 47 см байх ба 18-50 см-ийн хооронд ажиглагдана. Нугын хүрэн хөрс нь давслаг, сийрэг, бөөмөнцөр зэрэг физик шинж чанарыг агуулдаг.

Голын хөндийн хөрс нь Эрдэнэцагаан сумын нийт нутгийн 7%-ийг эзэлнэ. Аллювийн гаралтай өөрөөр хэлбэл урсгал буюу голын усны нөлөөн дор үүссэн хөрсүүд багтана. Ийм хөрс үүсэх гол нөлөөг ус үзүүлнэ. Тухайн бүс нутгийн ус чийг ихтэй нам дор газар буюу голуудын сав газраар тархсан. Энэ хөрсний онцлог нь газрын гадарга нь нугархаг зүлэгжсэн байна. Аллювийн нугын хөрсний өнгөн гадарга нь дов сондуул ихтэй, микро гадарга илүү хөгжсөн, ус чийг элбэгтэй, түүнд зонхилсон намгийн өвслөг, дэрслэг сөөг голлосон ургамлын дор явагдана.

Ялзмагт үе нь харавтар саарал, хөх саарал өнгөтэй доошлох тусам элсэрхэг болж харилцан адилгүй өнгөтэй ба механик бүрэлдэхүүн нь үелэн тогтсон байдгаараа бусад хөрснөөс онцлогтой юм.

**Ордын гидрогеологийн нөхцөл:** Нүүрс агуулагч хурдас нь элсэн чулуу, алевролит, гравеллит, конгломерат зэрэг терриген гаралтай чулуулгаас бүрэлдэх ба нүүрсний гол давхаргууд нь элсэн чулууны үе дотор байна.

Дээр дурдсан нүүрс агуулагч хурдас нь ордын нийт талбайд дөрөвдөгчийн элс, шавранцар, гравий, галькаас бүрдсэн сэвсгэр хурдсаар хучигджээ. Хучиж буй дөрөвдөгчийн хурдасны литологи бүрэлдэхүүнийг үзэхэд уг хурдас нь хур тунадасны ус нэвчин шингэхэд тохиромжтой болно.

Өрөмдлөгийн явцад усны түвшингийн хэмжилт хийснээр цооногуудад ус 11.0-15.0м-ээс илэрч 6-7м өгсөж тогтож байна. Өөрөөр хэлбэл нүүрс агуулсан хурдас газар доорх ус нь бага даралттай байна. 1, 7, 10-р цооногуудыг жижиг цахилгаан насосоор шавхаж үзэхэд усны түвшин 5.0-8.0м буурч усны ундарга 3.7 л/сек-ээс их ундаргатай байсан. Шавхалтын явц: Статик түвшин газрын гадаргаас 9.2 м байна.

Тус талбай эх газрын эрс тэс уур амьсгал, бага хур тунадасны хэмжээ, түүнээс давамгайлах ууршилт, рельефийн өндрийн хэлбэлзэлийн ялгаа их, хурдас хуримтлагах үйл явцуудын тогтворгүй байдал зэргүүдээс үзэхэд гидрогеологийн нөхцөл нийлмэл бөгөөд дээрх гидрогеологийн структуруудад гидрогеологийн давхарга зүйн хувьд янз бүрийн уст давхарга, цогцолбор, бүрдлүүд харилцан адилгүй тархжээ. Тусгай зөвшөөрөлийн талбайд дараах төрлийн уст үе давхарга, бүрдлүүд бүрэлдэн тогтжээ.

### **3.2 Төсөл хэрэгжиж буй нийгэм, эдийн засгийн төлөв байдал**

Эрдэнэцагаан сумын төв нь Монгол орны зүүн бүсэд, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн зүүн хэсэгт, нийслэл Улаанбаатар хотоос зүүн зүгт 768 км, аймгийн төв Баруун-Уртаас 216 км, Бичигтийн хилийн боомтоос 75 км-ийн зайтай оршдог. Мөн улсын хөгжлийн гол тэнхлэг болох Мянганы замаас 141 км, бүсийн хөгжлийг тэтгэх босоо тэнхлэгийн төлөвлөгдсөн замаас 5 км-т тус тус оршдог. Сумын нутаг дэвсгэрийн баруун урд талаар Дарьганга, баруун хойт талаар Асгат, Сүхбаатар сумуудтай, хойт талаараа Дорнод аймгийн Матад, зүүн болон урд талаараа БНХАУ-ын Шилийн гол аймагтай тус тус хиллэдэг.

Төслийн талбай нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт харьяалагдах бөгөөд Эрдэнэцагаан сумын төвөөс урагш 50 км, Баруун-Уртаас зүүн урагш 265 км, Улаанбаатар хотоос зүүн тийш 720 км, Бичигтийн боомтоос баруун урагш 78 км-т оршино. Ордын төв цэгийн солбицол Уртраг 115°21'24.07" Өргөрөг 45°28'11.09" байршина.

Сүхбаатар аймгийн нутгийн хилийн нийт урт 1340 км бөгөөд урд талаараа БНХАУ-тай 485 км, баруун талаараа Дорноговь аймагтай 165 км, хойд талаараа Хэнтий аймагтай 260 км, зүүн хойд талаараа Дорнод аймагтай 430 км газраар тус тус хиллэдэг.

Эрдэнэцагаан сум нь 8 баг, 1564 өрх, 6527 хүн амтай, 180.5 мянган толгой малтай, аймгийнхаа зүүн бүсийн томоохон сумдын нэг болоод байна. Сумын хүн амын ихэнх нь халх, үзэмчин, хуучид, дарьганга ястангаас бүрдэнэ. Сумын ИТХ, Засаг дарга, түүний тамгын газар, 11 жилийн дунд сургууль, хүн эмнэлэг, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв зэрэг төсөвт байгууллагууд, банкны салбарууд, хувийн мал эмнэлэг 3, худалдаа үйлчилгээ эрхэлдэг хоршоо, компани зэрэг аж ахуйн нэгж байгууллагууд, хилийн цэргийн анги, Онцгой байдлын газрын гал түймэртэй тэмцэх салбар, цагдаагийн газар болон төрийн бус байгууллагууд байдаг.

Олон улсын зэрэглэлтэй байнгын ажиллагаатай Бичигт-Зүүн хатавчийн хилийн боомтоор одоогоор Эрдэнэцагааны Баянцогт, Хулман нуурын нүүрсний уурхайнуудаас нүүрс, Дорнодын Тамсагаас газрын тос тээвэрлэн гаргаж байгаа бөгөөд цаашид төмөр зам, хурдны засмал замаар холбогдсон үйлдвэр, худалдаа арилжааны төвлөрсөн боомт хот болж хөгжих төлөвтэй байна

## **4 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

### **4.1 Төслийн болзошгүй гол сөрөг нөлөөлөл**

Сайн хөөврийн хүрэн нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс төсөл хэрэгжих явцад ордыг ухаж, ачих,

тээвэрлэх, овоолго үүсгэх, чулуулгын овоолгоноос тоос үүсэж салхины нөлөөгөөр орон зайд тархах нөлөөллийг хамгийн бага байлгахын тулд тоног төхөөрөмж ажиллаж буй талбай, мөрөгцөгийг тогтмол хэвийн хэмжээнд байлгах.


#### Байгаль орчинд:

Хүснэгт №05 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ

| №                | Төслийн үйл ажиллагаа           | Нөлөөллийн үнэлгээ |      |     |        | Нийт | БО-ны ангилалын үнэлгээ |
|------------------|---------------------------------|--------------------|------|-----|--------|------|-------------------------|
|                  |                                 | Бага               | Дунд | Их  | Маш их |      |                         |
| 1                | Агаарын чанар                   | 3                  | 3    | 5   | 2      | 13   | 12%                     |
| 2                | Амьтны аймаг                    | 16                 | 7    | -   | -      | 23   | 21%                     |
| 3                | Гадаргын болон газрын доорхи ус | 6                  | 2    | 7   | -      | 15   | 14%                     |
| 4                | Газрын гадарга болон хэвлий     | 3                  | 2    | 3   | 10     | 18   | 17%                     |
| 5                | Ургамлан нөмрөг                 | 8                  | 13   | 1   | -      | 22   | 20%                     |
| 6                | Хөрсөн бүрхэвч                  | 2                  | 5    | 10  | 1      | 18   | 17%                     |
| Нийт / тоогоор / |                                 | 38                 | 32   | 26  | 13     | 109  | 100%                    |
| Нийт / хувиар /  |                                 | 35%                | 29%  | 24% | 12%    | 100% |                         |

Сайн хөөвөр нүүрсний ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тооцоход нийт 37 сөрөг нөлөөллийг тооцсон бөгөөд үүний 1 буюу 3% нь “Маш бага”, 14 буюу 38% нь “Бага”, 16 буюу 43% нь “Дундаж”, 6 буюу 16% нь “Их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Үүнээс дүгнэхэд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь дундаас их түвшинд байна. Төслийн үйл ажиллагаанаас 181,3 га талбай эвдрэлд өртөхөөр байна. Тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг даган мөрдөж ажилласан тохиолдолд сөрөг нөлөөллийг зохих түвшинд барих боломжтой гэж дүгнэж байна.

#### ҮНЭЛГЭЭ



#### Хүний эрүүл мэндэд:

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, тэслэгээ, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдал зэрэг уурхайн ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нийт 31 нөлөөллийг тооцов. Тэдгээр нөлөөллүүдийн 14 буюу 45% бага, 17 буюу 55% нь дунд зэргийн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна.

Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА тухай хууль, бусад холбогдолтой дүрэм журам, стандартын шаардлагуудыг мөрдөх, дотоодын хяналтын журам аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг нийт ажилтнуудад мөрдүүлэх, хяналт тавих шаардлагатай.

### **Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл**

Сайн хөөврийн хүрэн нүүрсний ордыг ашиглах явцад агаарын чанарт нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд нь:

- Хөрс хуулах, нүүрс олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ
- Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэн тоос, шороо
- Уурхайн машин техникүүдийн түлшний шаталтаас ялгарах утаа, тортог, хорт хийнүүд
- Ажилчдын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол
- Өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо

Хөрс хуулах, түрэх, тээвэрлэх зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, авто машин бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна барилга угсралтын үйл ажиллагаа болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор агаарын бохирдол үүсч болзошгүй.

Төлөвлөж буй төслийн барилгын үйл ажиллагааны явцад тоосжилт мөн уурын зуухны үйл ажиллагаанаас үүдэлтэй утааны бохирдол тухайн бүс нутгийн уур амьсгалын нөхцөлтэй уялдан их, бага хэмжээгээр үүсэх учраас энэ асуудлыг зайлшгүй авч үзнэ. Төсөл хэрэгжих орчны хуурай уур амьсгал, хүчтэй салхи шуурга зэрэг нь төслийг төлөвлөх болон хэрэгжүүлэх шатанд холбогдох зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй бол ихээхэн хэмжээний тоосжилт орчиндоо бий болгох эрсдэлтэй.

Тэсэлгээ хийх, хөрс хуулах, төслийн талбайгаас уурхайд ашиглагдаж байгаа хүнд даацын техникүүдийн дизель түлшний шаталтын дунд ялгарсан утаа, хорт хий агаарыг бохирдуулах магадлалтай. Ажлын явцад олон салаа зам үүссэнээс орчин тойрны ургамал их хэмжээгээр талхлагдаж, хөрс эвдрэлд орсноор агаарын хөдөлгөөний харьцангуй бага утгын нөлөөгөөр тоосжилт үүснэ.

Тухайн орчнд байгалийн болон антропологийн гаралтай агаарын бохирдлын ямар нэг илрэл байхгүй бөгөөд цаашид энэхүү цэнгэг агаартай орчны унаган төрхийг хадгалан өөрсдийн эрхлэх уул уурхайн үйл ажиллагаандаа дэвшилтэт арга технологи ашилах нь зүйтэй.

### **Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл**

Одоогийн байдлаар газрын гадарга болон хэвлийд их хэмжээний эвдрэл болон нөлөөлөл байхгүй. Төслийн зүгээс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол нөлөөлөл нь барилга угсралтын ажил болон төслийн үйл ажиллагаатай холбоотой уурхайн малталт, овоолго болон тээврийн хөдөлгөөн зэрэг эх үүсвэрүүдээс үүсэх юм.

Уурхайн барилга угсралтын үед уурхайн төлөвлөгдсөн талбай нь барилгын материалыг тээвэрлэх замаар эвдэгдэх талбай харьцангуй бага байна. Учир нь одоо ашиглагдаж байгаа орон нутгийн болон улсын чанартай авто замуудыг ашиглах бүрэн боломжтой байна.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт байрлах “Бадмаараг хаш” ХХК-ний эзэмшил талбайд үүссэн эвдэрсэн газрын хохирлын хэмжээг тогтоохоор хийсэн судалгаа болон хөрсний шинжилгээн дээр үндэслэн “Эко Мастер” ХХК-ийн шинжээчдийн баг 2025 онд хийж гүйцэтгэв.

Судалгааны талбай нь нийт лицензийн хүрээнд 755 га бөгөөд талбайн хүрээнд нам ухаа гүвээ болон тэдгээрийн хоорондох хөндий хотгор, чийгэрхүү сайр бүхий д.т.д 1190-1235 м өндөртэй газарт байрлана. Судалгаанд хамрагдсан талбайд Монгол орны хөрсний ангиллаар Хархүрэн хөрсний дэд хэв шинжид багтах ердийн ба карбонаттай, глейрхэг (нугархаг) төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин дунд зэрэг, шимт үе давхарга

нь дунд зэрэг зузаан (0-40 см), бөөмөрхөг болон багананцар бүтэцтэй, механик нөлөөлөлд тэсвэртэй, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж дунд зэрэг байдаг онцлогтой. Мөн нэлээд шаварлаг буюу нарийн ширхэгтэй тоос болон шаврын агууламж өндөртэй байна. Хөрсний үе давхарга нь ихэвчлэн А-Вса-Сса гэсэн дараалалтай, хөрсний дээд үе давхаргын (0-30 см) ялзмагийн агууламж дээд үе давхаргад 3.2%, доод үе давхарга карбонатжилттай, урвалын орчин 7.56 буюу дунд зэрэг шүлтлэг, хялбар уусах давсжилт бага буюу 0.82 dS/m буюу багаас дунд зэрэг давсархаг байна. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд дунд ширхэгтэй тоосон фракц зонхилсон шавранцар бүрэлдэхүүнтэй байна. Нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсний өнгөн үе давхарга дахь хортой болон био-идэвхт хүнд металлын агууламж стандартын хүлцэх агууламжаас ноцтой хэтэрсэн тохиолдол байхгүй хэвийн түвшинд байна. Төслийн талбай дахь хөрсний эвдрэл талхагдал өнөөгийн байдлаар нийтдээ 213 га (нийт лицензийн хэмжээнд) талбай ямар нэгэн байдлаар нөлөөлөлд өртсөн байна.

Хөрсний экологи эдийн засгийн үнэлгээ тооцох эвдэрсэн газрын хэмжээ нийт 0.28 га талбай байна. Уг судалгааны ажлын дүнгээр эвдэрсэн газрын хэмжээ, хохирлын дүн гаргуулсан. Мөн техникийн нөхөн сэргээлт хийх газрын хэмжээ, төсвийг тооцоолуулав.

### **Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл**

Төсөл хэрэгжих талбай орчим хар хүрэн хөрсний хэв шинж зонхилон тархсан байна. Чулуурхаг хар хүрэн, сайргархаг хар хүрэн хөрс, ердийн хар хүрэн, элсэнцэр хар хүрэн, ойн ширэгт, ойн бараан зэрэг хөрс тархсан байна. Уурхайн дэд бүтцийн барилга угсралт, өрөмдлөг, тэсэлгээ, нүүрс олборлолт, тээвэрлэлт, овоолго зэрэг уулын бүхий л ажил үржил шимт хөрс, ургамлан бүрхэвчийг зайлуулж, газар ухаж хэлбэр, гадаргууг өөрчилж байгалийн унаган төрхийг алдагдуулна.

Төсөл хэрэгжих талбайн хөрс 15-30 см үржил шимт үетэй, өнгөний жижиг хайрган хучилтаар нар салхинаас хамгаалагдаж байдаг. Хайрган хучилт нь нимгэн тул хүн малын хөл, машин техникийн мөрөөр нунтаг хөрс ил гарч бургидаг онцлогтой. Ийм газрын үржил шимт хөрсийг хуулхад чийг алдагдаж хөрс салхинд хийсч тоос дэгдэнэ. Хэдийгээр төслийн талбайн орчмын хөрс нь цөлийн, элэгдэл эвдрэлд ихээр өртсөн боловч өнгөн хөрс нь ургамлан нөмрөгийг дэмжих, хөрсний чийгшлийг хадгалах онцгой ач холбогдолтой.

### **Төслөөс гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл**

Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс гадаргын болон газрын доорх усны нөөц, чанарт нөлөөлөл бий болш болзошгүй. Үүнд:

- Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дархад цэвэр усны нөөц хомсдох
- Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох
- Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих улмаар гүний усыг бохирдуулах
- Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химийн бодис алдагдахаас үүдэн хөрс болон гүний усыг бохирдуулах
- Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрснийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг бохирдуулах
- Техник тоног төхөөрөмжийн шатах тослох материал алдагдаж хөрснийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах

### **Төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл**

Төслийн талбайд ил уурхайн байгуулах, шимт хөрсний болон хаягдал чулуулгийн овоолго бий болгох, уурхайн зам, дэд бүтцүүдийн барилгын ажил хийгдэх зэрэгтэй холбоотойгоор хөрс хуулалт явагдах ба эдгээр үйл ажиллагаа нь ургамлан нөмрөгт шууд болон шууд бус нөлөөллийг үзүүлнэ.

Уурхайн байнгын үйл ажиллагаа ургамлан нөмрөгт дам нөлөөлөл богино ба урт хугацаанд үзүүлсээр байна.

### Төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Машин механизмын нөлөөлөл нь туруутан болон махчин амьтдад их нөлөөтэй, шавж, мөлхөгчидөд бага зэргийн нөлөө үзүүлж байна. Харин хөрс ашиглалт болон ажилчдын нөлөөлөл нь мэрэгчид, мөлхөгчид болон сээр нуруугүйтэнд их нөлөө, амьдрах орчны доройтол нь амьтны аймагт ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болхоор байна. Төслийг хэрэгжүүлэх явцад дор дурдсан сөрөг нөлөөллүүд гарч болзошгүй. Үүнд:

- Уурхайн олборлолт явуулах үед ажиллах хүнд даацын авто машин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих
- Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох
- Тоосжилтын улмаас ургамал ургах чадвараа алдан ургамлын арви багассанаас өвсөн тэжээлтнүүд хоол тэжээлийн хомсдолд орох
- Төслийн ажилчид санаандгүй болон санаатайгаар амьтадыг устгаж болзошгүй
- Шувууд утаанд хордох, цахилгаан хүчдэлд цохиулах зэрэг багтана.

Хүснэгт №06 Төслийн гол сөрөг нөлөөлөл

| № | Байгаль орчны хүчин зүйлс | Гол сөрөг нөлөөлөл                                                                                                                                                                                                                 |
|---|---------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Газрын гадарга, хөрс      | Уурхайн овоолгын доорх хөрс, ургамал нь бүр мөсөн дарагдаж, эргэж буцалтгүйгээр устана.                                                                                                                                            |
| 2 | Агаар                     | Нүүрсийг олборлох, ачих, тээвэрлэх, овоолго үүсгэх зэрэг үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед их хэмжээний тоос болон бусад төрлийн химийн бодис агаарт дэгдэж хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй. |
| 3 | Ургамал                   | Нийт талбайн ургамлан бүрхэвч устаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Овоолго үүсгэх, газрын ургамал устаж үгүй болж ургамлан бүрхэвчийн хэмжээ, бэлчээрийн талбай багасна.                                      |

### Байгалийн гамшгаас үүсэж болшгүй осол

Ослын үндсэн шалтгаан нь Байгалийн гамшигт үйл явц (үер, газар хөдлөлт) болон хүний үйл ажиллагааны алдаа болдог. Байгалийн гамшгаас үүсэх болон болзошгүй осолд газар хөдлөлт, усны үер, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймэр, үйлдвэрлэлийн осол, халдварт өвчин тархах зэрэг үзэгдлүүд хамаарна.

#### Аянга цахилгаан

Байгалийн гаралтай болзошгүй аюул нь аянга цахилгаантай борооны үед аянга буух, улмаар гал түймэр гарах, түлш, шатах тослох материал, тэсэрч дэлбэрэх явдал юм. Төсөл хэрэгжих бус нутаг нь жилд орох дуу цахилгаантай аадар бороо харьцангуй их байдаг тул цахилгаан хуваарилах байгууламж трансформаторын систем, агаарын шугамууд, тэсрэх бодис болон түлшний агуулах хамгийн өндөр эрсдэлтэй объектуудад тооцогдоно.

#### Аадар бороо

Төсөл хэрэгжих орчмын бүс нутагт аадар бороо их ордог ба задгай сайр ихтэй. Эрчимшил их түр зуурын аадар борооны үед уурхайн үйл ажиллагаа түр хугацаанд зогсох газрын хөрс, барилга байгууламж, дэд бүтцийн байгууламж нурж сүйдэх, уурхай усаар дүүрэх, дэд бүтцийн байгууламж эвдэрч сүйдэх, цахилгаан тасрах зэрэг эрсдэлтэй.

### Үер

Тус бүс нутагт жилд дунджаар 300 мм хур тунадас унах бөгөөд үүнээс ойролцоогоор 90% нь дулааны улиралд түр зуурын хүчтэй аадар бороо хэлбэртэй унадаг. Нэг хоногт ихээхэн хур тунадас орох нь өвөл зуд болох, зун хөрсний гадаргын угаагдлыг ихэсгэн үржил шимийг муутгахаас гадна гэнэтийн аюултай үзэгдлийн нэг үерийн эрсдэлийг дагуулах зэргээр мал аж ахуй, зам тээвэрт бэрхшээл учруулдаг. Эрчимшил их түр зуурын аадар борооны дараа үер буух аюултай бөгөөд үерийн улмаас үйлдвэрлэл зогсох, хүний амь эрсдэх, бэртэж гэмтэх, дэд бүтэц, барилга байгууламж үерт автан эвдэрч сүйдэх карьерт их хэмжээний хур борооны ус орж уурхайн олборлолтын үйл ажиллагаа түр зогсох, карьерийн хана, хаягдал хүдрийн далан нурах, сэтрэх, уурхайн эдэлбэр орчмын хөрс элэгдэх, цахилгааны богино холболт үүсэж болзошгүй. Мөн уурхайн карьерт их хэмжээний хур борооны ус орж уурхайн шүүрлийн устай холилдсоноос уурхайн усны төлбөр өсөх эрсдэлтэй.

### Шороон шуурга

Төслийн хэрэгжих талбай нь хээрийн бүсэд орших бөгөөд хаврын улиралд хүчтэй шороон шуурга, хүчтэй салхи ихээр босдог. Мөн уурхайн олборлолт, тээвэрлэлт, өрөмдлөг тэсэлгээний үед тоос шороо ихээр босдог. Их хэмжээний тоос нь уурхайн техник, тоног төхөөрөмжүүд тэдгээрийн сэлбэг хэрэгслүүдийн насжилтыг багасгана. Байгалийн шороог шуурга нь тал хээрийн бүсэд хавар идэвхждэг бөгөөд энэ тохиолдолд онц байдал зарлаж үйл ажиллагааг бүрэн зогсооно. Үзэгдэх орчин хязгаарлагдмал болсон үед аваар, осол гарах нөцөл бүрдэнэ. Хүчтэй шороон шуурга салхи нь ажилчидын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоох, хаягдлын овоолго нурах зэрэг аюултай.

### Халдварт өвчин

Төсөл хэрэгжиж буй бүс нутагт тахал олон нийтийг хамарсан тахал, халдварт өвчин гарснаар хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулна. Хөдөлмөрийн чадвар түр хугацаанд алдах эрсдэлтэй.

## **5 2026 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлуулах, тайлагнах журам”-ыг удирдлага болгов.

Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.

2026 оны байгаль орчны менежментийн үйл ажиллагааны гол арга хэмжээ нь сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, осол эрсдлийн менежментийг сайжруулах ба байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нийт **104,846,000.0 / Зуун дөрвөн сая найман зуун дөчин зургаан мянга/** төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт №07

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

| № | Бүрэлдэхүүн хэсэг                                               | Төсөв /мян.төг/ |
|---|-----------------------------------------------------------------|-----------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө            | 21,550,000      |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө                                    | 37,000,000.0    |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө                   | 15,400,000.0    |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | -               |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө          | -               |
| 6 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө                          | 6,500,000.0     |

|                                                                     |                                                                                                                                               |                      |
|---------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|
| 7                                                                   | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө                                                                                                          | 4,800,000.0          |
| 8                                                                   | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр                                                                                                            | 3,796,000.0          |
| 9                                                                   | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө                                                                                                      | 15,800,000.0         |
| 10                                                                  | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө,<br>төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад<br>тайлагнах төлөвлөгөөний | -                    |
| <b>2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв</b> |                                                                                                                                               | <b>104,846,000.0</b> |

## 6 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| №                    | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд                                                                                                                                                                                                                                            | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                                                                                        | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж                                      | Баримтлах эрх зүйн баримт бичиг                                                                                                                        |
|----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|-------------|---------------------|------------|------------------|-------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                      | 1                                                                                                                                                                                                                                                                               | 2                                                                                                                                      | 3                             | 4           | 5                   | 6          | 7                | 8                                                                 | 9                                                                                                                                                      |
| <b>Агаарын чанар</b> |                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                        |                               |             |                     |            |                  |                                                                   |                                                                                                                                                        |
| 1                    | Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд:<br>- Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил<br>- Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэд явж | Уурхайн олборлолтын үед тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх                                                                          | Уурхайн талбайд               | м.куб       | 777                 | 2650 м.куб | 3,000,000        | Нэг жилд 265 удаа усалгаа хийх /нэг удаагийн усалгааны норм 10м³/ | "АГААРЫН ТУХАЙ" ХУУЛЬ<br>"АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ" ХУУЛЬ<br>MNS4585:2016<br>MNS5885:2008<br>MNS ISO4227-2002<br>MNS3384:1982<br>MNS4990-2000 |
| 2                    |                                                                                                                                                                                                                                                                                 | Дотоод тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах | Үйл ажиллагаа эхлэхийн өмнө   | ширхэг      | 200,000             | 4          | 800,000          | Жилд 1 удаа                                                       |                                                                                                                                                        |
| 3                    |                                                                                                                                                                                                                                                                                 | Уурхайгаас дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох                                                                  |                               | -           | -                   | -          | 1,000,000        | ҮА-ний турш                                                       |                                                                                                                                                        |

|                         |                                                                                                                                            |                                                                                                                                                                                                    |                    |        |           |   |                  |                                                             |                                                                                |
|-------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|--------|-----------|---|------------------|-------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------|
| 4                       | буй машинуудаас<br>ялгарах хорт<br>бодисуудаар орчны<br>агаар бохирдох<br>- Бутлуурын<br>үйлдвэрийн үйл<br>ажиллагаанаас<br>үүсэх тоосжилт | Тээврийн хэрэгслийн<br>бүрэн бүтэн байдлыг<br>шалгаж, хаалга цонхны<br>чигжээс, хамгаалалтын<br>үзлэгийг хийж агаарыг<br>цэвэршүүлэх төхөөрөмж<br>хэрэгслийг бүрэн бүтэн<br>байдлыг хангаж ажиллах | Уурхайн<br>талбайд | ширхэг | -         | - | 500,000.0        | Техникийн<br>үзлэгийн<br>хуудсыг<br>өдөрт 2 удаа<br>бөглөх. |                                                                                |
| 5                       |                                                                                                                                            | Хүнд машин механизмын<br>утааны хэмжээг<br>стандартын шаардлага<br>хангах хэмжээнд байлгах,<br>үзлэг шалгалтыг хийх<br>засвар үйлчилгээг тогтмол<br>хийх                                           | 2026 он            | -      | -         | - | 800,000          | Тогтмол                                                     | MNS5885:2008<br>стандартын<br>дагуу                                            |
| <b>Нийт дүн сая.төг</b> |                                                                                                                                            |                                                                                                                                                                                                    |                    |        |           |   | <b>6,100,000</b> |                                                             |                                                                                |
| <b>Хөрсөн бүрхэвч</b>   |                                                                                                                                            |                                                                                                                                                                                                    |                    |        |           |   |                  |                                                             |                                                                                |
| 1                       | Ордын ашиглалтын<br>явцад хөрсний<br>бүтэц найрлагад<br>өөрчлөлт орох, хог<br>хаягдал,<br>тоосжилтоос                                      | Олборлолт нэмэгдэх бүрд<br>шимт хөрсийг хуулж,<br>тусгай талбайд<br>стандартын дагуу<br>байршуулж, хэлбэржүүлж<br>хамгаалах                                                                        | 2026 он            | -      | -         |   | ҮА-ний<br>зардал | Шаардлагатай<br>тохиолдол                                   | MNS<br>5915:2008<br>MNS<br>3307:1991<br>MNS<br>3308:1991                       |
| 2                       | бохирдол үүсгэх,<br>хүнд даацын<br>машин                                                                                                   | Техникийн эвдрэл<br>гэмтлийг зориулалтын<br>талбай (засварын цех)-д<br>байрлуулж засах,<br>ШТМ-ийг стандартын                                                                                      | 2026 он            | ширхэг | 5,000,000 | 1 | 1,500,000        | Үйл<br>ажиллагаа<br>эхлэхийн<br>өмнө 1 удаа<br>ц            | Хөрс хөрсний<br>химийн<br>элементүүдийн<br>нийт хэмжээг<br>тодорхойлох<br>арга |
| 3                       | механизмууд олон<br>салаа зам гаргаж<br>хөрс болон<br>ургамлыг гэмтээх.                                                                    | шаардлага хангасан<br>саванд хадгалах<br>хадгалалтанд хяналт тавих                                                                                                                                 |                    |        |           |   |                  |                                                             |                                                                                |

|                         |                                                                                                                                            |                                                                                                                                                                        |                      |        |          |   |                  |                                |                                                                                               |
